



АВТО БОЛОН ЯВГАН ЗАМ ЗАСВАРЫН АЖИЛ (УЛААНБААТАР ХОТ, БАЯНЗҮРХ ДҮҮРЭГ 42 ДУГААР ХОРОО)-ЫН ЗҮРГИЙН ДААЛГАВАР

2024 оны 01 дүгээр сарын 22-ны өдөр

Улаанбаатар хот

1	Зураг төсөл боловсруулах үндэслэл	- Баянзүрх дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн 15 дугаар хуралдааны 80 дугаар тогтоол;
2	Байршил, эдэлбэр газрын хэмжээ	- Баянзүрх дүүргийн 42 дугаар хорооны нутаг дэвсгэрт туслах зам, байр хорооллын дундах авто болон явган зам засвар, шинэчлэлтийн ажлыг 800 м2 талбайд хийх;
3	Зориулалт, хүчин чадал	<u>Авто замын нөхөөс, засвар шинэчлэлт:</u> <ul style="list-style-type: none">- Төрөл 1-эвдэрсэн хучилтын хэсгүүдийг хуулан авч оронд нь 70 мм зузаан урьдчилж хольсон жижиг ширхэгтэй халуун асфальт бетон хольцыг дээр нь дэвсэнэ.- Төрөл 2-эвдэрсэн хучилтын хэсгүүдийг хуулан авч оронд нь 220 мм зузаан хольцыг дээр нь дэвсэх, ингэхдээ доод 150 мм зузаан хэсгийн оронд буталсан чулуун суурь үеийг дэвсэн нягтруулж, дээд 70 мм зузаан хэсгийн оронд Төрөл 1-т дурдсан нөхөөсийг хийнэ.- Төрөл 3-эвдэрсэн хучилтын хэсгүүдийг хуулан авч оронд нь 520 мм зузаан үе дэвсэх, ингэхдээ доод 300 мм зузаан үед урьдчилж хүйтэнд тэсвэртэй хайрган материал, хайрган элс эсвэл хайргархаг хөрсийг дэвсэн нягтруулж, түүний дээр 220 мм зузаантай Төрөл 1 ба 2-т дурдсан нөхөөсийг хийнэ. Нөхөөс хийх талбай болон нөхөөсний төрлийн талаар хяналтын инженер заавар өгнө.- Засварын ажил нь замын гадаргуу дээрх нүх, үйрэлт, овойлт, хагарлууд, хөлдөлт гэсэлтээс үүдсэн эвдрэл болон үйрэлт үүссэн боржур солих ажлаас бүрдэнэ;
4	Зураг төслийн бүрдэл	<u>Зураг төсөлд тавигдах шаардлага:</u> <ul style="list-style-type: none">- Хэмжилтийн зураг, төсвийг боловсруулж, холбогдох байгууллагуудтай зөвшилцөн батлуулах;
5	Зураг төсөл зохиох үе шат, хугацаа	- Захиалагч, гүйцэтгэгч талуудын хооронд байгуулсан гэрээнд заасан хугацааг үндэслэл болгох;
6	Зураг төслийн байгууллага	- Захирамжийн дагуу сонгон шалгаруулалтаар шалгарсан байгууллага байх;

7	Хөрөнгө оруулагч	- Баянзүрх дүүргийн Засаг даргын Тамгын газар;
8	Инженерийн хангамж	- Эрх бүхий байгууллагаас холбогдох саналыг авч зураг төсвийг боловсруулан угсралтын ажлыг хийж гүйцэтгэх;
9	Онцгой нөхцөл	<u>Анхаарах зүйл:</u> <ul style="list-style-type: none"> - Орчин нөхцөл байдалд уялдуулан төлөвлөхдөө бат бөх чанартай материал сонгох; - Тендерт үнийн санал ирүүлэхдээ газар дээр нь судалж, ажлын тоо хэмжээг тооцож ирүүлэх; - Ажлын зураг төсвийг боловсруулж, баталгаажуулсны дараа угсралтын ажлыг эхлүүлэх;
10	Төлөвлөлтөд тавигдах шаардлага	<u>Дараах байгууллагуудтай заавал зөвшилцсөн байна:</u> <ul style="list-style-type: none"> - Баянзүрх дүүргийн Засаг даргын Тамгын газар; - Холбогдох бусад байгууллагатай;
11	Ерөнхий төлөвлөгөө, Зураг төсөв боловсруулах	<u>Хууль тогтоомжууд:</u> <ul style="list-style-type: none"> - Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хууль; - Барилгын тухай хууль; - Газрын тухай хууль; - Хот байгуулалтын тухай хууль; <u>Норм, нормативууд:</u> <ul style="list-style-type: none"> - “Хотын стандарт-Барилга, замын ажил гүйцэтгэхэд иргэдийн аюулгүй байдлыг хангах ерөнхий шаардлага” UCS 0301B стандартыг мөрдөх; - “Хотын стандарт-Явган хүний зам, талбайн төлөвлөлт, хучилт, угсралтад тавих шаардлага” UCS 0901B стандартыг мөрдөх; - Явган хүн, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан замыг төлөвлөх заавар (MNS6056:2009); - Хот, тосгоны төлөвлөлт, барилгажилтын норм ба дүрэм /БНБД 30-01-04/; - Барилгын орчны тохижилтын ажлын норм ба дүрэм /БНБД 3.01-06-90/; - Авто замын байгууламжийн засвар, арчлалтын ажлын техникийн шаардлага; - Авто замын байгууламжийн засвар, арчлалтын ажлын үйлдвэрлэлтийн жишиг норм; - MNS:4596:2014; - Бусад холбогдох норм, дүрэм; <u>Төсөл, хөтөлбөрүүд:</u> <ul style="list-style-type: none"> - Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл; - Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр; - Баянзүрх дүүргийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр;

12	Эдийн засгийн тооцоо, төсөв	- Төсвийг ESTIMATOR-PRO программ болон бусад зохих эрх бүхий байгууллагаас зөвшөөрсөн бусад программаар тооцох;
----	-----------------------------	---

ХЯНАСАН:
ТӨЛӨВЛӨЛТ, ГҮЙЦЭТГЭЛИЙН
УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.ДАВААСАМБУУ

БОЛОВСРУУЛСАН:
ТӨЛӨВЛӨЛТ, ГҮЙЦЭТГЭЛИЙН УДИРДЛАГЫН
ХЭЛТСИЙН МЭРГЭЖИЛТЭН

М.БИЛЭГЖАРГАЛ

